



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 11/24

Арвайхээр сум

Өвс, тэжээл хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.5, 32.1.6 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх тухай” 461 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт хүндэрсэн зарим сумдад аймгийн Улсын нөөцийн салбараас 50 хувь хямдруулан олгох тэжээл, өвсний хуваарийг 1, дээрх сумдад хуваарилсан нөөцийн барааны түгээлтэд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 2 хавсралтаар тус тус баталсугай.

2.Өвөлжилт хүндэрсэн сумдуудад өвс, тэжээл хүргэх тээврийн зардлыг тухайн сумд хариуцан гаргахыг сумын Засаг дарган нарт даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6223 11 0049

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны  
 дүгээр сарын 18.-ны өдрийн  
 дугаар захирамжийн  
 1.дүгээр хавсралт

**УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР ЦЭГЭЭС СҮМДАД 50 ХУВИЙН  
ХЯМДРАЛТАЙ ҮНЭЭР ОЛГОХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ**

№	Сумын нэр	Ногоон тэжээл
1	Хархорин	15
2	Хужирт	14,83
		<b>29,83</b>

**УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР ЦЭГЭЭС СҮМДАД  
50 ХУВИЙН ХЯМДРАЛТАЙ ҮНЭЭР ОЛГОХ ХИВЭГНИЙ ХУВААРЬ**

№	Улсын нөөцийн салбар цэгийн нэр	Сумын нэр	Хивэг (25к) тонн	Хивэг (40кг) тонн	Долооц 18,3тн (хайрцаг)
1	136 дугаар салбар	Хархорин	30	20	50
		Хужирт	30	20	50
		Бат-Өлзий	30	20	50
		Бурд	20	20	50
		Есэнзүйл	20	20	20
		Онцгой комисс	27,13	0	0
2	Арвайхээр	Дүн	<b>157,13</b>	<b>100</b>	<b>220</b>
		Арвайхээр	20	20	50
		Зүүнбаян-Улаан	20	20	50
		Тарагт	20	20	50
		Уянга	30	20	50
		Онцгой комисс	16,26	20	50
3	Нарийнтээл	Дүн	<b>106,26</b>	<b>100</b>	<b>250</b>
		Нарийнтээл	4	20	40
		Хайрхандулаан	4	20	40
		Гучин-Ус	4	20	40
		Баруунбаян- Улаан	4	20	40
		Богд	4	20	39
		Онцгой комисс	4,35		
4	Сант	Дүн	<b>24,35</b>	<b>100</b>	<b>199</b>
		Сант	12	20	50
		Баян-Өндөр	12	20	50
		Өлзийт	12	20	50
		Баянгол	12	20	50
		Төгрөг	12	20	46
		Онцгой комисс	12,78	0	0
		Дүн	<b>72,78</b>	<b>100</b>	<b>246</b>
		<b>Нийт</b>	<b>360,52</b>	<b>400</b>	<b>915</b>
<b>Бүгд</b>				<b>778,82</b>	

Аймгийн Засаг даргын 2023 оны  
 01..дугээр сарын 18.-ны өдрийн  
 .....дугаар захирамжийн  
 .....дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН НӨӨЦИЙН ЦЭГЭЭС ОЛГОХ  
 ӨВСНИЙ ТҮГЭЭЛТИЙН БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ  
 АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Д. Одонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)

Гишүүд:  
 С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Ундармаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Улсын нөөцийн салбарын дарга, ахмад)

Д.Лхагважав (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын ахлах мэргэжилтэн)

Т.Эрдэнэбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

-оОо-